



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.04

№ 01/10.

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Э.СУГАРМАА ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бурэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар 40,000.0 /Дөчин мянга/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

- Холбогдох хууль журмыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн хяналтын тооллогоор 40,000.00 төгрөгийн 2 ширхэг сандал биетээр байгаагүй

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 4.4-т /Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх/ мөн хуулийн 73 дугаар зүйлийн 2-т / Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө бараа материал үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойши 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжсуулэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтөлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль журмын дагуу үр дүнтэй зохион байгуулах, хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллах
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 01-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын иргэдийн

110700712

Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Э.Сугармаа/, нягтлан бодогч /Т.Хүдэрчулун/ нарт хариуцулав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ

### ӨГСӨН<sup>1</sup>:

ШИНЖЭЭЧ

ЖАЛБАА



### ЗӨВШӨӨРСӨН:

иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.СУГАРМАА

НЯГТЛАН БОДОГЧ

Т.ХҮДЭРЧУЛУУН

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" ээж заасны даагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.